



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 366

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 286 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны ХЭГ/2475 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (хуучнаар Замын цагдаагийн газар)-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдаанд нэг ч оролцогч ирээгүй тул дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг худалдах нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тооцож 12,474,720,000.00 (арван хоёр тэрбум дөрвөн зуун далан дөрвөн сая долоон зуун хорин мянган) төгрөг дээр үнэлгээний ажлын зардал 7,000,000.0 (долоон сая) төгрөгийг нэмж 12,481,720,000.00 (арван хоёр тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая долоон зуун хорин мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3. Дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувь буюу 1,248,172,000.00 (нэг тэрбум хоёр зуун дөчин найман сая нэг зуун далан хоёр мянган) төгрөгөөр, үнэ өсгөх доод шатлалыг 10,000,000.00 (арван сая) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, нийтэд зарлахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000719

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 09 дүгээр сарын 16-ны
өдрийн 366 дүгээр тогтоолын хавсралт



ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
5 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ ДООД ҮНЭ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 121 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Бууруулсан үнэ		Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
			Хувиар	Төгрөгөөр	
1	Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 барилга байгууламж	13,860,800,000.00	10	1,386,080,000.00	12,474,720,000.00